



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 1158

Улаанбаатар хот

Нийслэлийн шүд, эрүү, нүүрний төвийн
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 58,370,000 /тавин найман сая гурван зуун далан мянган/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн шүд, эрүү, нүүрний төв /Б.Дөлгөөн/-д зөвшөөрсүгэй.
2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн шүд, эрүү, нүүрний төв /Б.Дөлгөөн/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 16 дугаар сарын 22-ны өдрийн 12/33 дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүрэг, Шүд, эрүү, нүүрний төв

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	нэр	Эх үүсвэр
1	Автоклав	SHINVA	XGI-UCD135M	2020	Сайн	ш	1	29,880,000	29,880,000	Тайваны Хүүхэд гэр бүлийг дэмжих сан	Хандив
2	Дэлгэмэл рентген аппарат	PointNix	800HD	2020	Сайн	ш	1	28,490,000	28,490,000	МУЗН	Хандив
Тоног төхөөрөмжийн дүн									58,370,000.0		

/Төгрөгөөр/